

Article

Types of organizational systems for the enforcement of civil court judgments

Byamba-Erdene Sukhbaatar^{1,2}

¹Department of Private Law, School of Law, University of Internal Affairs, Ulaanbaatar, Mongolia

²“Ikh Zasag” University, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: byaaba97@gmail.com



<https://orcid.org/0009-0005-6434-4181>

Received: 20 March 2026. Accepted: 20 May 2026. Published online: 15 June 2026

Abstract

In all countries, the purpose of enforcement proceedings in civil cases is essentially the same: to ensure the execution of legally binding court judgments and to restore the violated rights of the claimant. However, the methods by which civil court judgments are enforced, as well as the institutions responsible for their implementation, vary from country to country and possess distinct institutional characteristics.

In this article, I aim to examine how the systems of civil court judgment enforcement bodies are classified at the international level.

Keywords: Administrative model, Court-centred model (or Judicial model), Private enforcement system (or Private model), Civil case, hybrid system, Compulsory enforcement (or Enforcement proceedings), Enforcement officer (or Bailiff), Claimant (or Plaintiff) Defendant.



© 2026, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator. <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцооны хэлбэрүүд

Сүхбаатарын Бямба-Эрдэнэ^{1,2}

¹“Их засаг” их сургуулийн докторант, Улаанбаатар, Монгол улс

²Хувийн эрх зүйн тэнхим, Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургууль, Улаанбаатар хот, Монгол улс

Хураангуй

Улс орон бүрийн иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго ижил буюу хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах, нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршдог.

Харин улс орнуудын иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж байгаа арга хэлбэр, хэрэгжүүлэгч байгууллагууд нь тогтолцооны хувьд харилцан адилгүй өөр өөрийн гэсэн онцлогтой байдаг. Бид энэхүү өгүүллээрээ дамжуулан олон улсад иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог хэрхэн ангилдаг талаар өгүүлж, манай улсын иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь гадаадын зарим орны шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоонд хэрхэн нийцэж байгаа талаар харьцуулан судлахыг зорилгоо болгож, уншигч та бүхэнд шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцооны талаар өгүүлэхийг зорьсон болно.

Түлхүүр үг: Захиргааны загвар, Шүүх төвтэй загвар, Хувийн байгууллагын тогтолцоо, холимог тогтолцоо, албадан гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэгч,

Удиртгал

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний процессын эрх зүйн үргэлжлэл болохынхоо хувьд эдийн болон эдийн бус баялагтай холбоотой иргэний хэргийн маргааныг шүүхийн шийдвэр гарсны дараа төрийн албадлага хэрэглэх замаар шүүхийн шийдвэрийн биелэлтийг заавал хангуулах ач холбогдолтой байдаг.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гол объект болсон эдийн баялгийг хувийн болон нийтийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгө гэдгээр нь мэддэг бол эдийн бус баялгийг хөдлөх эд хөрөнгөнд хамаарах оюуны өмчтэй холбон тайлбарладаг.

Доктор Б.Буянхишиг бүтээлдээ “Иргэний хэрэг гэдэгт аливаа иргэн, хуулийн этгээдийн зүгээс эдийн болон эдийн бус баялагтай холбоотой, тухайлбал үнэт зүйл эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах зорилгоор шүүхэд хандахыг ойлгоно. Ийнхүү хувь этгээд хоорондын эдийн болон эдийн бус баялагтай холбоотой үүсэж болох эрх зүйн харилцааг дийлэнхдээ Монгол Улсын Иргэний хуулиар,

зарим харилцааг бусад тусгай хуулиар зохицуулсан байх бөгөөд иргэд эдгээр хуулинд зохицуулсан эрх, үүргийг хэрэгжүүлэхийн тулд шүүхэд ханддаг” гэж тайлбарласан байдаг (Б.Буянхишиг, 2021, хууд. 17). Бид доктор Б.Буянхишигийн үзэл бодолтой санал нэг байгаа бөгөөд иргэний хэрэг бол эдийн болон эдийн бус баялагтай холбоотой асуудлаар иргэний журмаар шүүхэд хандаж зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд шаардлагатай хүсэлт, гомдол, нэхэмжлэлийг шүүгчийн захирамжаар иргэний хэрэг үүсгэн хавтаст хэрэг болгосон байдал юм.

Эдийн болон эдийн бус баялагтай холбоотой асуудлаар үүссэн талуудын маргааныг иргэд харилцан тохиролцож, зөвшилцөж шийдвэрлэж чадахгүй тохиолдолд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхийг хүссэн тал буюу нэхэмжлэгч нь шүүхэд хандаж, шүүх иргэний хэрэг үүсгэж, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, улмаар шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болсон тохиолдолд хариуцагч шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх үүрэг хүлээдэг билээ.

Судлаач Ч.Өнөрцэцэг бүтээлдээ “Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эд хөрөнгө, мөнгө гаргуулах, тодорхой үүрэг гүйцэтгэх эсхүл гүйцэтгэхгүй байхыг даалгах, орон сууц, байшин, барилга, байгууламж, агуулах сав, газар чөлөөлөх, нураах, хүүхэд гаргуулах, шилжүүлэх, хүүхэд уулзуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, ажилд эгүүлэн томилох, төлбөр авагчийг барилгах байшинд оруулах албадлагын арга хэмжээ хамаарна” гэж тайлбарлажээ (Ч.Өнөрцэцэг, 2022, хууд. 7). Иргэний хэргийг шүүх хянан шийдвэрлэж шүүхийн шийдвэр гарч, хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр биелэгдэхгүй бол албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсыг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, иргэдийг эрхийг хамгаалахад албадлагын арга хэмжээний үр дүн болно.

Шүүхийн шийдвэр биелэгдэх гол нөхцөл болсон “Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэгч, төлбөр авагч, төлбөр төлөгчийн хооронд төлбөрийг биелүүлэхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааны нийлбэр байна. Уг ажиллагаанд оролцох субъектийн хувьд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, өмгөөлөгч, төлөөлөгчийн хооронд үүсэж болох харилцаа байдаг” (Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, 2017).

Хариуцагч буюу төлбөр төлөгч шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй байгаа тохиолдолд нэхэмжлэгчийн хүсэлтээр шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжийг албадан гүйцэтгэх тухай шүүгчийн захирамж, шүүгчийн гүйцэтгэх хуудсыг шүүгч бичиж нэхэмжлэгчид олгодог. Нэхэмжлэгч буюу төлбөр авагч нар шүүхийн шийдвэр, эвлэрлийг баталж хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамжийг албадан гүйцэтгэх тухай шүүгчийн захирамж, шүүгчээс бичиж олгосон гүйцэтгэх хуудсыг албадан гүйцэтгүүлэх

шаардлагаар иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэгчид хандвал төлбөр барагдуулах ажиллагаа эхэлж, хариуцагч шүүхийн шийдвэрийг биелүүлж дуусах хүртэл хугацаанд уг ажиллагаа үргэлжилдэг.

Бид энэхүү өгүүлээрээ дамжуулан Монгол Улсын Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог гадаадын зарим орны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоотой харьцуулан судалснаа уншигч та бүхэндээ толилуулах болно.

Үндсэн хэсэг:

Олон улсад Шүүхийн шийдвэр биелүүлэх чиг үүрэгтэй байгууллагыг санхүүжүүлж байгаа эх үүсвэрээр шүүхийн тогтолцоотой, гүйцэтгэх эрх мэдлийн төрийн албан хаагчийн тогтолцоотой, холимог, хувийн гэж 4 хэлбэрт хуваан авч үздэг.

1. “Шүүхийн тогтолцоотой буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг шүүх эрх мэдлийн шүүхийн “шийдвэр гүйцэтгэгч” хэрэгжүүлдэг бөгөөд гүйцэтгэх засаглалаас хараат бусаар шүүхийн хяналтанд үйл ажиллагаа явуулдаг Австри, Словени, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг орнууд хамаарна”.
2. “Төрийн албан хаагчийн тогтолцоотой буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг гүйцэтгэх эрх мэдлийн Хууль зүйн яамаар дамжуулан хэрэгжүүлдэг ХБНГУ, Швед, Финланд, Малта, Монгол Улс орнууд багтана”.
3. “Хувийн байгууллагын тогтолцоотой буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь шүүхээс хараат бусаар зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулдаг Польш, Белги, Булгар, Чех, Эстони, Франц, Грек, Унгар, Латви, Люксембург, Нидерланд, Португал, Романиа, Шотланд, Словак, Словени зэрэг улс орнууд гэж тус тус ангилна”.
4. “Дан шүүхийн эсхүл төрийн албан хаагчийн тогтолцооноос гадна хувийн аж ахуйн нэгжүүд шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг холимог тогтолцоотой Франц, Болгар, Казахстан улсад хувийн байгууллагаас гадна төрийн шийдвэр гүйцэтгэгч байдаг байна”.

Оросын эрдэмтэн Д.В.Аристов, В.А.Гуреев нар бүтээлдээ “Шүүхийн болон төрийн албан хаагчийн тогтолцоог шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрийн тогтолцоо гэж авч үздэг бол хувийн байгууллагын тогтолцоо нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хувийн тогтолцоонд хамаарна. Дан шүүхийн эсхүл төрийн албан хаагчийн тогтолцооноос гадна хувийн аж ахуйн нэгжүүд шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг холимог тогтолцоотой улс орнууд бий. Жишээ нь, Франц, Болгар, Казахстан улсад хувийн байгууллагаас гадна төрийн шийдвэр гүйцэтгэгч байдаг байна” гэж тэмдэглэжээ (С.Сүхбаатар, 2022, хууд. 9). Бид дээрх эрдэмтэдтэй санал нэг байгаа бөгөөд тухайн улс нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх

байгууллагын тогтолцоогоо төрийн, хувийн байгууллагын эсхүл холимог тогтолцоотой байлгаж болно гэж үзэж байна.

Профессор Вэнди Кэнэтт бүтээлдээ “өөр өөр эрх зүйн тогтолцоо бүрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны арга барил ялгаатай байдаг хэдий ч гурван институцийн загвараар бүлэглэж болно” гэж бичжээ (Kennett, 2021, хууд. 9). Түүний гаргасан загвар нь:

1. “Захиргааны загвар буюу нийтийн болон хувийн эрх зүйн санхүүгийн үүргийн хэрэгжилтийг төрийн удирдлагын нэг хэсэг болох гүйцэтгэх байгууллага хариуцдаг явдал юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид төрийн албан хаагчийн статустай байдаг. Швед, Финланд улсууд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн энэ загварын цорын ганц төлөөлөгч юм”.

2. “Шүүхийн ажилтны загвар буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны загвар нь улсуудад хамгийн өргөн хэрэглэгддэг загвар бөгөөд гарал үүсэл нь 14-р зууны Францаас улбаатай гэж үздэг. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний шийдвэр гүйцэтгэх чиглэлээр мэргэшсэн ажилтан гүйцэтгэж, үзүүлсэн үйлчилгээгээрээ орлого олдог. Зарим улс оронд Шүүхийн ажилтнууд зөвхөн иргэний болон арилжааны асуудлаар дагнаж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хариуцан ажилладаг. Бусад тохиолдолд тэд нийтийн эрх зүйн салбарын хүрээнд өр барагдуулах үүрэгтэй боловч өөр нэмэлт ажлуудыг мөн гүйцэтгэдэг онцлогтой”.

3. “Шүүх төвтэй загвар буюу шүүх болон шүүхийн шийдвэрийн биелэлтийг хүртэл хариуцдаг (мөн бусад шийдвэр гүйцэтгэх эрхийг хэрэгжүүлнэ). Шүүх тодорхой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг (бараа хураан авах гэх мэт) эхлүүлэхийн тулд төлбөр авагчийн гаргасан өргөдлийн үндсэн дээр арга хэмжээ авдаг”.

Бид профессор Вэнди Кэннэтийн захиргааны загвар, шүүхийн ажилтны загвар, шүүх төвтэй загварыг иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад байж болох тогтолцооны загвар гэж үзэж байна.

“Европын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай ном зохиолд тэмдэглэснээр "шийдвэр гүйцэтгэх эрх" гэдэг нь үүргийг биелүүлэхийн тулд төрийн эрх мэдлийг ашиглах, тэр дундаа шаардлагатай бол хүч хэрэглэхийг зөвтгөх шүүхийн шийдвэр, захирамж болон бусад баримт бичгүүдийн ерөнхий нэр томъёо юм. Тиймээс иргэний эрх зүйн хүрээнд шийдвэр гүйцэтгэх эрхийн баримт бичигт иргэний болон арилжааны хэргийн шүүхийн шийдвэр, нотариатаар гэрчлүүлсэн (жинхэнэ) баримт бичиг орно. Эрх зүйн тогтолцооноос хамааран шүүхээс бусад байгууллагаас олгосон чек, вексель, төлбөрийн даалгавар, арбитрын шийдвэр болон бусад хэрэглүүр нь мөн гүйцэтгэх эрхийн бичиг байж болдог гэж тодорхой заажээ” (С.Сүхбаатар, 2022, хуудсд. 7-8).

“Төлбөр авагчид болон тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Зарим тогтолцоонд төлбөр авагч бусдаасаа давуу эрх

мэдлийг олгодог (жишээ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрлийг сонгох). Энэ нь их хэмжээний мөнгөн эрсдэлд орсон болон төлбөр авагч төлбөр төлөгчийн талаар маш их мэдээлэлтэй байгаа эсвэл бусад шалтгаанаар шийдвэр гүйцэтгэх тодорхой стратеги хэрэгжүүлэхийг хүсэж байгаа тохиолдолд хэрэгцээтэй байдаг”.

“Шүүх төвтэй эсхүл холимог загвартай улс орнуудад иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр авагчийн гаргасан хүсэлтийн дагуу явуулах бөгөөд дараах иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг түгээмэл авч хэрэгжүүлнэ”.

1. “Хөрөнгө хураах, худалдах (биет хөдлөх хөрөнгө)”.
2. “Гуравдагч этгээдийн хөрөнгийг хураах (ихэвчлэн банкны данс, орлого эсвэл цалин хөлс, гэхдээ аливаа нэхэмжлэлд хамаарах боломжтой)”.
3. “Үл хөдлөх эд хөрөнгийг хураах (өр барагдуулах мөнгө олох зорилгоор худалдах, захиран зарцуулах, жишээлбэл, түрээсийн орлого эсвэл бүтээгдэхүүн борлуулах замаар)”.
4. “Шийдвэр гүйцэтгэх эрхийг хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэх, ингэснээр бүртгэлтэй эд хөрөнгийг зээлдүүлэгчид төлбөр төлөхгүйгээр худалдах боломжгүй”.
5. “Хорих болон жолооны үнэмлэх, ан агнах зөвшөөрлийг түдгэлзүүлэх зэрэг бусад шийтгэл зэргийг тус тус нэрлэж болно”.

Профессор Вэнди Кэнэтт бүтээлдээ “Орчин үед иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэчлэх үйл явц нь төлбөр төлөгчийн хөрөнгө, орлогод гарсан өөрчлөлтөөс ихээхэн шалтгаалж байна. Биет хөрөнгөөс биет бус хөрөнгө рүү шилжих, орлогын төрлийг төрөлжүүлэх нь эд хөрөнгө, газрыг хураахад чиглэсэн арга хэмжээ авах уламжлалт арга барицыг хангалтгүй болгож байгаа нь шийдвэр гүйцэтгэх практикийн гол шинж чанар болсон” гэж тэмдэглэжээ (Kennett, 2021).

Төрийн албан хаагчийн тогтолцоотой шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрөөс санхүүжилтээ авч, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэний хувийн нууцад хамаарах мэдээллийг авах эрхийг хуульчилсан байх ёстой. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн цалин, хөлсийг улсын төсвөөс олгодог тул шүүхийн шийдвэрт заасан төлбөрийн хэмжээнээс үл хамааран төр нь шүүхийн шийдвэр биелүүлэх баталгаа болдог.
- “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь өндөр үнийн дүнтэй гүйцэтгэх хуудаснаас төлбөр гаргуулах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эсэхээс үл хамааран бүхий л шүүхийн шийдвэрт ажиллагаа явуулж, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангана”.

- “Олон даргад захирагдахгүй чиглэлийн нэгдмэл удирдлагатай байх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, шийдвэр гүйцэтгэгчид хуулийг нэг мөр хэрэглэх боломжийг бүрдүүлнэ”.

“Харин хувийн тогтолцоо нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төрөөс үл хамааран явуулдаг тул чадвартай шийдвэр гүйцэтгэгчийг төлбөр авагч өөрөө сонгож, богино хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох боломж олгодог. Төлбөр авагч шүүхийн шийдвэрийг хамгийн богино хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлж чадах байгууллагыг сайн дурын үндсэн дээр чөлөөтэй сонгох боломжийг олгодог”.

“Иргэний хэргийн шийдвэр шийдвэр гүйцэтгэх төрийн болон хувийн тогтолцоог гурван талаас нь харьцуулан үзэхэд: Төрийн албаны хувьд иргэдийн зүгээс төр түүнийг төлөөлөх шийдвэр гүйцэтгэх байгууллагад итгэх, түүнийг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг харгалзан үзэх хэрэгтэй”.

“Хувийн тогтолцоотой үед төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг нь биелүүлэхэд тодорхой хэмжээнд бэрхшээлтэй байдаг. Мэргэжлийн үйл ажиллагаа талаас нь харахад шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн хувьд төрийн тогтолцоонд багтаж төрийн нэрийн өмнөөс ажиллах нь хамгийн тааламжтай байдаг. Учир нь шийдвэр гүйцэтгэгчийн ажлын байр, цалин орлого илүү баталгаатай, тогтвортой болдог”.

“Харин хувийн шийдвэр” гүйцэтгэлийн байгууллага, шийдвэр гүйцэтгэгчийн хувьд шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлснээс шууд хамааралтайгаар түүний орлого хэмжигдэх бөгөөд өөрийн ажилчиддаа олгох цалин хөлс, оффисын түрээс, тоног төхөөрөмжийг зардлыг бүгдийг нь хариуцдаг, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангалтгүй гүйцэтгэвэл төлбөрийн чадваргүй болох эрсдэл өндөр үүрдэг.

Зах зээлийн талаас нь харахад хувийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллага, гүйцэтгэгч нь ашгийн төлөө ажилладаг учраас төлбөр төлүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна. Нөгөө талаас нь харвал зөвхөн ашиг харж ажиллах тул шударга, үр дүнтэй шийдвэр гүйцэтгэл хүн чанаргүй гэх тодотголыг төлбөр төлөгч нарт төрүүлж байдаг сул талтай (С.Сүхбаатар, 2022, хууд. 10).

Оросын эрдэмтэн Д.В.Аристов, В.А.Гуреев нар бүтээлдээ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрийн, хувийн эсхүл холимог тогтолцоог сонгох эсэх нь эрх зүйн тогтолцооноос бус тухайн улсын эдийн засаг, улс төр, захиргааны болон бусад хүчин зүйлээс шалтгаалдаг. Иймд нэг улсад үр дүнтэй хэрэгжиж буй тогтолцоог өөр нэг улс авч хэрэгжүүлснээр үр дүнтэй байна гэсэн үг биш юм” гэж тэмдэглэжээ (С.Сүхбаатар, 2022, хууд. 25). Дээрх үзэл санааг сийрүүлбэл, бид гадаадын зарим орны иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцооны онцлогийг энд илэрхийллээ гээд манай улсын шийдвэр гүйцэтгэх байгууллагын

тогтолцоог сайн гэж бодсон улс орны шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог шууд нэвтрүүлэх оролдлого хийж болохгүй гэсэн үг юм.

“Барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг хураах (ялангуяа ипотекийн зээлийн хэрэг) нь төлбөр авагчийн эрхийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байж болох бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэх байгууллагууд ч процессын явцад бичиг баримтын үйлчилгээ үзүүлэхээс авхуулан шаардлагатай тохиолдолд эд хөрөнгөд халдах замаар оролцдог. Энэ ажиллагааг гүйцэтгэхэд гуравдагч этгээдээс шийдвэр гүйцэтгэх байгууллагад туслалцаа үзүүлэхийг шаардаж болдог онцлогтой байна”.

Профессор Вэнди Кэнэттийн үзэж буйгаар “Тухайн үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилж, хураасны дараа хөрөнгийн үнийг бодитой болгох журмыг эхлүүлнэ. Хөдлөх эд хөрөнгийг хураан авах үүрэгтэй байгууллага нь ихэвчлэн худалдах ажиллагааг хариуцдаг ч дуудлага худалдаагаар мэргэшсэн мэргэжилтнүүдийг мөн ажиллуулж болно. Үл хөдлөх эд хөрөнгө эрх ашгийн хувьд илүү төвөгтэй байдаг тул шүүхийн оролцоо их байдаг. Учир нь цэвэр өмчийн эрхээс гадна хариуцагчийн үндсэн эрх, өрхийн бусад гишүүдийн эрх, ашиг сонирхол хөндөгддөг. Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн аль алиныг нь худалдахад цахим дуудлага худалдаа явуулах явдал улам бүр нэмэгдэж байна. Эдгээрийг ихэвчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор бүтээсэн тусгай дижитал платформоор дамжуулан зохион байгуулдаг боловч зарим улс оронд арилжааны сайтуудыг ашиглаж байна” гэж иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүх эрх мэдлийн хүрээнд дуудлага худалдааны шинэ хэлбэрийн талаар тодорхой дурджээ (С.Сүхбаатар, 2022, хууд. 11). Монгол Улсад үл хөдлөх эд хөрөнгийн цахим дуудлага худалдааг хөгжөөгүй байгаа бөгөөд дээрх хэсэгт цахим дуудлага худалдааны талаар өгүүлсэн нь сонирхол татдаг.

Мөн тэрээр “Нэгээс дээш нэхэмжлэлтэй төлбөр төлөгчийн тодорхой хөрөнгийг хураан авах үед аль төлбөр авагчийн шаардлага нэн тэргүүнд хангагдах ёстой вэ гэдгээс хамааран шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлнэ. Хэрэв хураан авсан хөрөнгө нь нэгээс илүү өрийг төлөхүйц өндөр үнэтэй биш бол дараагийн төлбөр авагчид хураан авах өөр хөрөнгө хураан авч өгдөг. Зарим улс орнууд бүх төлбөр авагчидтай адил тэгш харьцдаг, эсхүл төлбөр авагчдад давуу эрх олгох тухай өөр зохицуулалтыг хийсэн байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхийн ажилтан гүйцэтгэдэг улсуудад тухайн албан тушаалтан хөрөнгийг хураан авахдаа гуравдагч этгээдийн бараа борлуулснаас олсон орлого, төлбөрийг хуваах асуудлыг мөн шийдвэрлэдэг. Шүүхийн ажилтан нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой борлуулалт, удирдлагын орлогыг хуваарилах бүрэн эрхтэй байж болох ч шүүх, нотариатын оролцоо шаардагддаг” гэж тэмдэглэсэн байна (Kennett, 2021, хуудсд. 30-33).

Төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүй хүү, торгууль, алдангийг ХБНГУ, Норвеги, Швед, Япон, БНСУ, Сингапур, Эстони төлбөр төлөгчид оногдуулдаг байна. Гэрээгээр зохицуулаагүй байсан ч шийдвэр гүйцэтгэгчдэд ийнхүү төлбөр төлөгчөөс хугацаандаа төлөөгүй нөхцөлд хүү, алданги, торгуулийг авах эрхийг олгосон байдаг (Европын сэргээн босголт, 2025). Монгол Улсад өр төлбөрөө төлөхгүй удаж олон жилийн дараа төлбөр төлөхөд хүү, алданги төлөхгүй өрөө төлөх боломж байдаг сул талтай байдаг.

“Мөн төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагын БНСУ, ХБНГУ, Гүрж Улсын туршлагаас харахад шийдвэр гүйцэтгэлийн шүүх нь үүргээ биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгчийг торгох, баривчлах хөшүүргийг хэрэглэдэг байна (Монгол Улсын Хууль зүй, 2025). Монгол Улсад төлбөр төлөгч нарыг төлбөрөө төлөөгүйн төлөө баривчлахгүй бөгөөд зөвхөн торгодог нь учир дутагдалтай учраас ирээдүйд баривчлах хөшүүргийг ашигладаг болох хэрэгтэй гэж үзэж байна.

Дүгнэлт

Олон улсын түвшинд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог хэлбэрийн хувьд шүүхийн, төрийн албан хаагчийн, хувийн гэсэн үндсэн дөрвөн хэсэгт хувааж ангилсан нь өндөр ач холбогдолтой болжээ. Гадаадын зарим улс орнууд болох ХБНГУ, Швед, Финланд, Малта зэрэг улс орнуудын иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь Монгол Улстай нэгэн адил төрийн албан хаагчийн тогтолцоотой гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад харьяалагддаг. Эх газрын эрх зүйн бүлийн Монгол Улс нь гүйцэтгэх эрх мэдлийн буюу төрийн алба хаагч төвтэй иргэний шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог төлөвшүүлсэн байгаа нь эх газрын эрх зүйн бүлийн Герман Улсын шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоотой адил төстэй байна. Харин Австри, Словени, Бүгд Найрамдах Солонгос зэрэг улс орнуудын иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь шүүхийн тогтолцоотой буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг шүүх эрх мэдлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлдэг бөгөөд гүйцэтгэх засаглалаас хараат бусаар зөвхөн шүүхийн хяналтанд үйл ажиллагаа явуулдаг онцлогтой.

Гэтэл “Польш, Белги, Булгар, Чех, Эстони, Франц, Грек, Унгар, Латви, Люксембург, Нидерланд, Португал, Романиа, Шотланд, Словак, Словени” зэрэг улс орнуудын иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь хувийн байгууллагын тогтолцоотой буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь шүүх эрх мэдлийн болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас ангид хараат бусаар зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулдаг зэрэг нь гагцхүү шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж, шүүхийн шийдвэрийг

биелүүлэх зорилгодоо нийцжээ.Түүнчлэн “Франц, Болгар, Казахстан Улсад хувийн байгууллагаас гадна төрийн шийдвэр гүйцэтгэгч ажиллаж, шүүхийн эсхүл төрийн албан хаагчийн тогтолцооноос гадна хувийн аж ахуйн нэгжүүд шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг” нь ихээхэн онцлогтой байна.

Оросын эрдэмтэн Д.В.Аристов, В.А.Гуреев нарын зүгээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрийн тогтолцоонд шүүх болон гүйцэтгэх эрх мэдлийн төрийн байгууллагууд хамаарах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувийн тогтолцоонд төр хамаарахгүй гэж үзсэн нь хувийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрөөс хараат бусаар үйл ажиллагаа явуулж байх ёстойг илэрхийлжээ.

Мөн иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог эрдэмтэн В.Кэннэттийн үзсэнээр зөвхөн нэгт, захиргааны буюу төрийн байгууллагын мэдэлд, хоёрт, шүүхийн ажилтны загвар буюу шүүхийн дэргэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албыг хариуцуулах, гуравт, шүүх төвтэй загвар буюу зөвхөн шүүх нь шүүхийн шийдвэрийн биелэлтийг хариуцан явуулдаг тогтолцооны хэлбэрүүд дэлхийд бүрэлдсэн байгаагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх эрх мэдлийн болон шүүх эрх мэдлийн төрийн байгууллага хэрэгжүүлэх нь түгээмэл ажээ.

Харин Монгол Улсын Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь дэлхийн зарим улс орнуудтай ижил ялангуяа эх газрын эрх зүйн бүлийн ХБНГУ-ын нэгэн адил гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад төвлөрсөн байна.

Манай улсад өр төлбөрөө төлөхгүй удах тусам төлбөр төлөгчид давуу байдал үүсч хүү, алданги нэмж төлдөггүй явдлыг гадаадын зарим орнууд шиг үндсэн төлбөр дээр хүү, алданги төлдөг болгох, төлбөрөө төлөхгүй тохиолдолд зөвхөн торгох бус баривчлах хөшүүргийг ашиглах талаар хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж үзлээ.

Эх сурвалжийн жагсаалт

- Kennett, W. (2021). *Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge* /Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцооны харьцуулсан судалгаа: Төрийн удирдлагын өмнө тулгарч буй сорилт/.
- Б.Буянхишиг. (2021). *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*. УБ: Соёмбо принтинг.
- Европын сэргээн босголт, х. б. (2025). *Зарим улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулийн зохицуулалтын харьцуулсан судалгаа*. УБ.
- Монгол Улсын Хууль зүй, д. х. (2025). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн товч танилцуулга*. <https://mojha.gov.mn> . УБ.

- С.Сүхбаатар, А. З. (2022). *Зарим орны шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцооны талаарх судалгаа, судалгааны тайлан*. Уб.
- Ч.Өнөрцэцэг. (2022). *Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт*. Уб: Соёмбо принтинг.
- Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. (2017). *Хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай лавлагаа*. . Уб.